

ИХ СУРГУУЛИЙН “ЭНТРЕПРЕНЕР” ЧИГ БАРИМЖААТАЙ ХӨГЖИЛ, ТҮҮНД НӨЛӨӨЛӨХ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН СУДАЛГАА

Д.Батцэцэг*, Н.Оюунжаргал**

Хураангуй: Мэдлэгт суурилсан нийгэм, эдийн засгийн хөгжил нь тухайн улс орны энтрепренершипийн хөгжилтэй шууд хамааралтай байдаг. Энтрепренер сэтгэлгээ, зорилго, үйл ажиллагаа нь шинэ технологийн хөгжлийг хурдасгаж улмаар нийгэмд ажлын байрыг бий болгон, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангаж байгааг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна. Энэ утгаараа дэлхийн улс орнууд энтрепренер түншлэлийн асуудал, түүний хөгжилд нөлөөлж буй хүчин зүйлүүд, оролцогч институциудын хамтын ажиллагаанд анхааралаа хандуулж, үр нөлөө бүхий зохицуулалтуудыг хийсээр ирсэн. Энтрепренершипийг хөгжүүлэхэд их сургууль, аж үйлдвэр, засгийн газрын хамтын ажиллагаа чухал байдаг. Цаашлаад энтрепренершипийн хөгжилд их сургуулиудын оролцоо, нөлөөлөл ихийн учир судалгаанд суурилсан их сургуулиас энтрепренер үзэл баримтлал бүхий их сургуулиуд олноор төрөн гарч буй нь глобал үзэгдэл /phenomenon/, чиг хандлага болоод байна. Их сургууль мэдлэгийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулахын тулд үйлдвэрийн аж ахуйн газрууд, засгийн газартай хамтран ажиллаж үр дүнд хүрэх нь энтрепренершипийг хөгжүүлэхийн гол ач холбогдол юм. Энтрепренершипийг хөгжүүлэхийн тулд их сургуулиуд өөрсдийн дотоод нөөц бололцоо, орчин нөхцлөө сайжруулах, зөв бодлого, зохицуулалтуудыг хийх зайлшгүй шаардлагатай байдаг. Энэхүү өгүүлэлээр МУ-ын их сургуулиуд энтрепренершипийг хөгжүүлэхэд дотоод өөрчлөлт, шилжилтийг хэрхэн хийж буйг судалгаа хийн үр дүнг харуулахыг зорьлоо.

Түлхүүр үгс: *Энтрепренершип, инноваци, энтрепренер их сургууль, их сургууль-аж үйлдвэр - засгийн газар хамтын ажиллагаа*

Universities entrepreneurial orientation development: A study on internal factors affecting entrepreneurship development

Abstract: Knowledge-based economic development has a direct relation with the entrepreneurship development of the country. It has been recognized that the entrepreneurial mindset, intention, and activities accelerate technology development which stimulating a knowledge-based economy and creates new jobs. In this matter, many countries have focused on the cooperation of different institutions engaged with entrepreneurship and the main factors influencing the development of the entrepreneurial ecosystem.

It is vital for entrepreneurship development that the cooperation between university, industry, and government. According to researchers, universities play a crucial role in developing entrepreneurial activities in societies. To increase the potential role of the university and significant contribution to entrepreneurship, universities shifted from their traditional role as education providers and scientific knowledge creators to a more complex entrepreneurial university model (Pon-Kam Wong 2006) that becomes a global phenomenon.

The universities need to enhance their internal resources and supportive condition through the appropriate regulations for entrepreneurship development. The purpose of this paper is to demonstrate universities' internal change and transition to entrepreneurial orientation.

Keywords: entrepreneurship, innovation, entrepreneurial university, cooperation between university, industry, and government

* Худалдаа Үйлдвэрлэлийн Их сургууль, (E-mail): dalhbattsetseg@yahoo.com

** Худалдаа Үйлдвэрлэлийн Их сургууль, (E-mail): oyunjargaln@gmail.com

Үндэслэл

Энтрепренершип бол мэдлэг, мэдээлийг шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ болгон хувиргах механизм юм (Scott Shane, S. Venkataraman 1997), энтрепренершип нь эдийн засаг дахь үр өгөөжгүй орон зайг илрүүлж түүнийг өөрчлөх механизм юм (Kirzner 1997), энтрепренершип нь бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд инновацийг бий болгож, өөрчлөлтийг авч ирдэг эдийн засгийн чухал хөдөлгөгч хүч юм (Schumpeter) гэж эрдэмтэд тодорхойлсон байдаг. Тэрээр анх эдийн засагч Шумпетер “энтрепренер”-ийг “бүтээлч сүйтгэгч”, “инноваци”-ийг “шинэ комбинаци” хэмээн томъёолсон байдаг. Энэ цаг үеэс шинэ санаа бүхий энтрепренер хүн, түүний өвөрмөц зан төлөв, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох, ашиглах, түгээх үйл явц, тэдгээрийн эдийн засгийн үр өгөөж, нөлөөлөх хүчин зүйлс зэргийг судласнаар “энтрепренер экосистем”, “энтрепренер их сургууль” гэх ойлголтууд бий болж одоог хүртэл судалгааны гол сэдэв хэвээр байна. Нийгэмд энтрепренер сэтгэлгээг бий болгох, соёлыг төлөвшүүлэх, энтрепренершип түншлэлийг хөгжүүлэхэд их сургуулийн манлайлал, санаачлага, үүрэг оролцоо их байгаа нь практикт нотлогдож судалгааны их сургуулиас энтрепренер их сургууль болж хөгжих чиг хандлага улам бүр нэмэгдсээр байна. Тэгэхээр нийгэм эдийн засгийн хөгжилд нөлөөлж буй талаасаа ч, их сургуулийн сургалт, судалгааны чанар, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж буй талаасаа ч манай улсад энтрепренершипийн хөгжлийн асуудлыг зайлшгүй судлах хэрэгцээ шаардлага байна гэж судлаачдын зүгээс харж энэхүү судалгааг хийсэн. Судалгааны ажлын үр дүнд нэгдүгээрт; их сургуулийн энтрепренер чиг үүрэг, энтрепренер үзэл баримтлалын талаар онолын судалгаа, хоёрдугаарт; манай улсын их сургуулиуд энэ чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлж байгааг зарим үзүүлэлтүүдийн хүрээнд судалгаа хийж дүгнэлт гаргалаа.

Академик хувьсгал, “Энтрепренер их сургууль”-ийн үүсэл хөгжил, үзэл баримтлал

Академик нэгдүгээр хувьсгалаар (19-р зууны сүүл үе) мэдлэг, соёлыг хадгалах, хамгаалах өвлүүлэх зорилго бүхий их сургуулиудын байр суурь өөрчлөгдөн шинжлэх ухаанч судалгааны ололт, амжилтыг практикт нэвтрүүлэх, сургалт судалгааг хослуулан ажиллах зорилтуудыг өмнөө тавьж эхэлсэн. Эдгээр зорилтууд нь академик хоёрдугаар хувьслын үед сургалт, судалгааг хослуулахын дээр их сургууль өөрөө энтерпренер байх, энтрепренер үйл

ажиллагаагаараа эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах гэсэн гуравдагч зорилтуудаар баяжигдсан. Энэ хувьсгал 1862 онд Массачусетсийн Технологийн Их Сургууль дээр “ланд грант” загвараар танилцуулагдаж байсан бол 20-р зууны эхэн үед “энтрепренер их сургууль” загвараар Станфордын их сургуульд амжилттай хэрэгжсэн түүхтэй байдаг. Тодруулбал академик нэгдүгээр хувьсал нь шинжлэх ухааныг хөгжүүлэн дэлгэрүүлсэн бол хоёрдугаар хувьсал нь түүнийг амьдралд хэрэгжүүлсэн юм. (H.Etzkowitz 2014).

Эрдэмтэн судлаачид; энтрепренер их сургуулийн эрхэм зорилго нь сургалт, судалгаа, энтрепренер үйл ажиллагааг хослуулан ажиллахад чиглэгддэг (H.Etzkowitz 2004); энтрепренер шинэ их сургуулийн зорилтууд нь нийгмийн хөгжил, эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулахад оршдог (Schulte 2004) гэж онцлон тэмдэглэсэн байдаг. Эрдэмтдийн тодорхойлсноор “Энтрепренер их сургууль” нь шинжлэх ухааны ололт, шинэ технологит суурилсан бүтээгдэхүүнийг бий болгох, түүнийгээ эзэмших, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, зах зээлд хүргэх, спин-офф болон гарааны компаниуд төрүүлэн гаргах зэргээр орлогын шинэ эх үүсвэрийг бий болгож буй институци юм. Тодруулбал их сургууль сургалт, судалгааны үндсэн чиг үүрэг дээрээ бизнес эрхлэх үүргийг давхар хүлээж буй хэрэг юм. Etzkowitz (2003), их сургуулиуд төрөлхийн инкубатор юм гэж тодорхойлсон нь угаас их сургууль нь мэдлэгийн эх уурхай бөгөөд мэдлэгийг эдийн засгийн эргэлтэд оруулахад өөрийн нөөц бололцоо хангалттай бий гэдгийг илэрхийлсэн байдаг. Энтрепренер их сургуулийн тодорхойлолт, тайлбаруудыг хүснэгт 1-т харуулав.

Хүснэгт 1. Энтрепренер их сургуулийн тухай тодорхойлолтууд

Эрдэмтдийн нэрс	Бүтээлийн хэвлэгдсэн он	Энтрепренер их сургуулийн тодорхойлолтууд
H.Etzkowitz	1983	...патент эзэмших, гэрээт судалгаа хийх, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдтэй түншлэх зэргээр хөрөнгийн шинэ эх үүсвэрийг бий болгож буй их сургуулиуд...
Chrisman et al	1995	... их сургуулийн профессор, ажилчид, оюутнууд нь шинэ бизнес бий болгож буй их сургууль...
B. Clark	1998	Энтрепренер их сургууль өөрөө хэрхэн бизнес хийхийг эрэлхийлж байдаг. Илүү ирээдүйтэй байхын тулд байгууллагын шинж чанарын чухал өөрчлөлтийг хийхийг зорьж байдаг


J. Ropke	1998	Энтрепренер их сургууль нь 3-н агуулгыг илэрхийлнэ. Үүнд: 1/ их сургууль өөрөө энтрепренер байх, 2/ Их сургуулийн гишүүд энтрепренер байх, 3/ их сургууль гадаад орчинтой харилцахдаа нь энтрепренер замыг дагах
Subotzky	1999	Энтрепренер их сургууль бол бизнесийн байгууллагатай ойр түншлэлтэй, гадаад санхүүжилтийн эх үүсвэрийг олж авахын тулд өндөр харилцаагаар ханддаг, засаглал, манлайлал, төлөвлөлтийн хувьд менежментийн ёс зүйг эрхэмлэдэг
D.A Kirby	2002	Энтрепренер их сургууль шинэчлэл өөрчлөлт хийх, боломжийг таньж мэдэх, бүтээх, багаар ажиллах, эрсдлийг үүрэх, аливаа сорилтод хариу өгөх чадвартай байдаг
H. Etzkowitz	2003	“Энтрепренер их сургууль бол төрөлхийн инкубатор юм
G. Jacob et.al	2003	Энтрепренер их сургууль бол шинэ бүтээгдэхүүнийг бий болгох болон түүнийгээ зах зээлд нэвтрүүлэх гэсэн үүргүүдийн хоёуланд төвлөрдөг онцлогтой

Энтрепренер байх (Ropke 1998, Jacob et.al 2003) чиг үүргийг хэрэгжүүлснээр их сургуулиудын сургалт, судалгааны чанар дээшилж, санхүүгийн хувьд бие даасан байх нөхцөл бүрддэг. Институцийн онолоор их сургуулиуд гадаад, дотоод орчны хүчин зүйлсийн нөлөөллийг удирдаж ажиллах нь зүйтэй бөгөөд юуны түрүүнд институцийн дотоод өөрчлөлт, шилжилтийг хийх шаардлагатай болдог. Институцийн дотоод өөрчлөлтийн хүрээнд их сургууль нь сургалт, судалгаа, энтрепренер чиг үүргүүдийг холбож нэгтгэсэн алсын хараа, стратегийг тодорхойлох, зохион байгуулалтын уян хатан бүтцийг бий болгох, шийдвэр гаргалт дахь хамт олны оролцоог нэмэгдүүлэх, мэдээлийн доороос дээш урсгалыг ашиглах, менежментийн засаглалын хувьд бие даасан (Clark, 1998) байхыг шаарддаг. Мөн соёлын хувьд байгууллагын нийт гишүүдийг энтрепренер байхад дэмжих, урамшуулалын оновчтой системийг нэвтрүүлэх, спин-офф, гарааны компаниудыг дэмжих механизмууд бүрдүүлэх шаардлага зүй ёсоор тавигддаг.

Энтрепренер их сургуулийн өөр нэг онцлог бол энтрепренер сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх байдаг. АНУ болон Европын орнуудад 1980 оны сүүлээс их дээд сургуулиудад, тэр дундаа бизнесийн сургуулиудад энтрепренершип сургалтын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн. Энтрепренершип сургалтын хөтөлбөрийн зорилго, сэдэв, арга барилууд нь оюутны бүтээлч болон шүүмжлэлт сэтгэлгээг хөгжүүлж, энтрепренер зан

төлөв, хандлага, ур чадварыг суулгаж өгдөг. Ингэснээр нийгэмд амжилттай ажиллаж буй энтрепренерүүдийг төрүүлэн гаргадаг ач холбогдолтой.

Их сургууль “энтрепренершип”-ийг хөгжүүлэхэд нөлөөлөх хүчин зүйлс, үр дүн




Энтрепренер их сургуулийн концепци нь сургалт, судалгааны үр дүнг үйлдвэрлэлд нэвтрүүлж, инновацийн хөгжилд мэдлэгийн үүрэг, ролийг нэмэгдүүлэхэд оршдог. Дэлхий нийтээр бүс нутгийн болон үндэсний инновацийн системд мэдлэгийг чухалчилах хандлага нь их сургууль бол мэдлэгийг бий болгож түгээдэг төдийгүй шинэ технологийг зардал багатайгаар шилжүүлэх институт бөгөөд энэ утгаараа үйлдвэрлэлийн инновацид томоохон үүрэгтэй оролцох шаардлагатай гэдгийг онцолж байна.

Triple helix загвар –Энтрепренер их сургууль

Энтрепренер их сургуулийн концепцийг тайлбарлах ‘triple helix’ загварыг эрдэмтэн Henry Etzkowitz, Loet Leydesdorff нар 1999 онд “The dynamics of innovation: from national system and mode 2 to a triple helix of university-industry-government relations” эрдэм шинжилгээний бүтээлээрээ харуулсан төдийгүй уг загвараар их сургууль нь мэдлэгт суурилсан нийгэмд инновацийг хөгжүүлэхэд голлох нөлөө үзүүлэхийг онцлон тэмдэглэсэн байдаг. Их сургууль-аж үйлдвэр-засгийн газрын хамаарлыг харуулсан ‘triple helix’ загвар нь оролцогч талуудыг тус тусдаа бие даасан бөмбөрцөг гэж авч үзэж бөмцөгүүдийн хажуугийн давхцалууд нь инновацийн систем дэх институтиудын хамтын ажиллагааны талбар бөгөөд эдгээр институтиуд нэг нь нөгөөгийнхөө чиг үүргийг хэрэгжүүлэх, харилцан ашигтай хамаарал бүхий байгууллагууд гэж тодорхойлоод мөн

завсрын холимог (hybrid) байгууллагын үүргийг тодруулсан байдаг.



Загварын зорилтууд нь 1) инновацийн орчин дахь их сургуулиас төрөн гарч буй спин-оффүүд, 2) мэдлэгт суурилсан эдийн засгийн загварыг бий болгох институциудын гурван талт санаачлагууд 3) академик судалгааны багууд, компаниуд, засгийн газрын стратегийн нийцлийг илрүүлэхэд оршдог.

Зураг 1. 'Triple helix' загвар, эх сурвалж Н.Etzkowitz, L.Leydesdorff, 1999

Ихэнх улс орнууд, бүс нутгийн хүрээнд энтрепренершип түншлэлийг хөгжүүлэхийн тулд Triple Helix загварын үзэл баримтлалын дагуу ажиллахаар зорьж байна. Энэ загвар нь зөвхөн их сургууль-аж үйлдвэр-засгийн газрын гадаад харилцан хамаарлыг харуулаад зогсохгүй институци доторх дотоод шилжилтийн хэрэгцээ шаардлагыг харуулсан байдаг. Тухайлбал их сургуулиуд сургалтын институтээс сургалт, судалгааг хослуулсан институт болох шилжилт зайлшгүй шаардлагатай байна. Их сургууль-аж үйлдвэр-засгийн газрын хамтын ажиллагааг хөгжүүлэх нь тодорхой үе шатуудаар дамжин хэрэгждэг бөгөөд дараах үе шат байдаг. Үүнд:

1. Институт тус бүрийн дотоод өөрчлөлт, шилжилт хийгдэх үе
2. Нэг институтын өөрчлөлт нөгөө институтын өөрчлөлтөд нөлөөлөх үе
3. Талуудын дунд харилцаа холбоо, сүлжээний шинэ давхцал бүхий завсрын байгууллагууд бий болох үе
4. Талуудын хамтын ажиллагаа нь тухайн нэг институт болон институт хооронд мөн нийгэмд нөлөө үзүүлэх үе

Дээрх дөрвөн үе шатын дагуу их сургуулиуд тодорхой дэвшилтэт механизмуудыг хэрэгжүүлснээр энтрепренер их сургууль болон хөгждөг. Үүнд:

1. Их сургууль уламжлалт сургалтын арга барилаа өөрчлөн дэвшилтэт аргазүйг ашиглах, шинэ чиг үүргийг хэрэгжүүлэх
2. Их сургууль нь үйлдвэрийн газар туршилт судалгаа хийсэний үр дүнд гарсан бүтээл, оюуны өмчийг ашиглах, шилжүүлэхтэй холбоотой тусгайлсан гэрээ хэлэлцээр, зохицуулалтууд хийх
3. Их сургууль бусад институциудтай (үйлдвэр, аж ахуйн нэгж, засгийн газар) ажиллахын тулд хүний нөөцийн чадавхиа дээшлүүлэх, оюуны өмчийн эрхийг шилжүүлэх, худалдаалах, хяналт тавих, гэрээ хэлэлцээр хийх зэрэг техник ур чадвараа хөгжүүлэх,

4. Бусад талуудтай хамтран ажилласнаар их сургууль гарааны компани бий болоход туслах, сургалт судалгаагаар дамжуулан инновацийг идэвхжүүлэхэд нөлөөлөх, манлайлах

Их сургуулийн ирээдүйн үүрэг нь **нэгдүгээрт** мэдлэгийн үйлдвэрлэлээр эдийн засгийн гүйцэтгэлтэй урьд өмнөхөөс илүү хамааралтай болох, **хоёрдугаарт** мэдлэгийн үйлдвэрлэл болон түүнийг нийгэмд ашиглах ирээдүйн чиг хандлагыг тодорхойлох Stehr (1994) гэсэн нь энтрепренер их сургуулийн ач холбогдлыг маш тодорхой харуулж өгсөн байдаг. Дээр дурьдсанчлан институциудын хоорондын хамаарал, хамтын ажиллагаа нь инновацийн үйл ажиллагаа, үр дүнг сайжруулахын дээр инновацийн орчныг бүрдүүлж байгаа их сургууль, үндэсний лабораториуд, томоохон компаниуд, старт-аппуудын хөгжилд хурдацтай өөрчлөлтийг авч ирдэг. Сургалт, судалгаа, бизнес үйл ажиллагааны салангид байдал нь тогтвортой хөгжилд саад болдог учир эдгээрийг нэгтгэх шаардлага зүй ёсоор урган гарч ирж байна. Хүснэгт 2-р их сургууль, аж үйлдвэр, засгийн газрын чиг хандлага, зорилго, бүтэц хэрхэн өөрчлөгдөж буйг харуулав.

Хүснэгт 2. Институциудын өөрчлөлт, чиг хандлага

Шинэ их сургууль	Шинэ үйлдвэр	Шинэ Засгийн газар
Энтрепренер их сургууль	Шинжлэх ухаанд суурилсан үйлдвэр	21-р зууны засгийн газар
Шинэ их сургуулийн эрхэм зорилго	Шинэ үйлдвэр	Шинэ Засгийн газар
ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛ		
Шинэ байгууллагын бүтэц	Шинэ байгууллагын бүтэц	Шинэ байгууллагын бүтэц
Салбаруудын холимог бүтэц Салбар хоорондын төвүүд Шинэ салбар, судалгаа Өөрийгөө санхүүжүүлэх байгуулага Нийгэм дэх манлайлал	Хамтын ажиллагааны төсөл, Их дээд сургуулиудын ойролцоо өндөр технологийн төвүүд	Шинэ сургууль болон шинэ үйлдвэр бий болгоход шинжлэх ухаан, технологийг хослуулсан дэд бүтэц бүхий шинэ засгийн газрын бүтэц

Судалгааны хэсэг

Судалгаагаар манай улсын их сургуулиудын энтрепренершипийн хөгжилд оруулж буй хувь нэмэр тэр дундаа мэдлэгийн үйлдвэрлэлээ аж үйлдвэрлэлтэй хэрхэн холбон ажиллаж буйг судлахыг зорьсон. Ингэхдээ судалгааны объектоор төрийн өмчит 4 их сургуулийг сонгон авсан. Судалгааг хийхдээ юуны өмнө их сургуулиудын дотоод гүйцэтгэлтэй холбоотой, зайлшгүй судлах шаардлагатай

зарим хүчин зүйлсийг авч үзсэний дээр их сургуулиуд үйлдвэрийн газруудтай болон засгийн газартай хэрхэн харилцан хамтран ажиллаж байгааг судлан дүгнэлт гаргав.

Судалгааны аргазүй: *Баримт бичгийн судалгааны арга зүйг ашиглан их сургуулиудын стратеги, бодлогын баримт бичгүүдэд харьцуулалт, шинжилгээ хийсэн. Мөн төрийн өмчит байгууллагуудаас авсан статистик мэдээллүүдийг ашиглалаа.*

Их сургууль – Энтрепренерт чиглэсэн дотоод үйл ажиллагаа


Энтрепренершипийг хөгжүүлэх, энтрепренер их сургууль болохын тулд их сургууль нь үйлдвэр, аж ахуйн нэгж, засгийн газар, судалгааны агентлагуудтай хамтран ажиллаж мэдлэгийг бий болгох, түгээн дэлгэрүүлэх үйл хэрэгт манлайлан оролцож “мэдлэг”-ийн эдийн засагт оруулах хувь нэмрийг өсгөх үүргийг хүлээдэг. Энтрепренершипийг хөгжүүлэхэд их сургуулиуд:

1. Мэдлэг, ур чадвар, бүтээлч сэтгэлгээ бүхий ажиллах хүчин, энтрепренерүүдийг бэлтгэх, тэднээр дамжуулан нийгэмд энтрепренер соёлыг түгээх,
2. Судалгааны үр дүнд бий болсон шинэ технологи, бүтээгдэхүүний патент, оюуны өмчийн эрхээ эзэмших, арилжаалах,
3. Технологи дамжуулах төв, инкубатор, судалгааны төвүүдээр дамжуулан спин-офф, старт-апп компаниудыг төрүүлэн гаргах, үйл ажиллагааг дэмжих,
4. Үйлдвэр аж ахуйн нэгжүүдтэй хамтарсан судалгаа, төсөл хэрэгжүүлэх, засгийн газрын төсөл хөтөлбөрүүд дээр хамтран ажиллах, судалгааны үр дүнгээ хуваалцан бодлогын түвшинд саналаа оруулах зэргээр улс орон, бүс нутгийн инновацийн системд голлох үүрэг гүйцэтгэдэг.

Үүний тулд их сургуулиуд юун түрүүнд дотоод шинэчлэл өөрчлөлт хийж алсын хараа, стратегиа зөв тодорхойлж, бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтөд орох шаардлагатай бөгөөд бакалаврын болон төгсөлтийн дараах сургалтын хөтөлбөрүүдээ шинэчлэн боловсруулах, оюутан, багш, судлаач, ажилчдыг энтрепренер үйл ажиллагааг дэмжих, *гүйцэтгэл, урамшуулалын оновчтой системийг хэрэгжүүлэх* болоод оюуны өмч, патентын ашиглалтыг зөв удирдлагаар хангах шаардлага урган гардаг.

Бид дотоодын их сургуулиудын хувьд судалгаанд суурилсан энтрепренер их сургуулийн чиг үүрэг хэрэгжүүлэхэд бэлэн байгаа эсэхэд дүн шинжилгээ хийсэн. Үүнд: 1/ төрийн өмчит их сургуулиудын алсын хараа, эрхэм зорилго,

стратеги төлөвлөгөөг, 2/ багш судлаачдын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, урамшуулалын системийг харьцуулан судаллаа.



Их сургуулиудын алсын хараа, эрхэм зорилго, стратеги төлөвлөгөөнд хийсэн судалгаа

Их сургууль-аж үйлдвэр-засгийн газрын гэсэн гурван институцийн хамтын ажиллагаа нь инновацийг идэвхжүүлж, өндөр технологи бүхий гарааны компаниудыг олноор төрүүлж улс орны хөгжлийг хурдасгадаг. Ингэхдээ эхлээд институциуд дотороо өөрчлөлт, шинэчлэл хийсэн байх хэрэгтэй байдаг (H.Etzkowitz “Triple helix” загвар). Тиймээс судлаачдын зүгээс төрийн өмчит дөрвөн их сургуулиудын сонгон авч эрхэм зорилго, алсын хараа, стратеги төлөвлөгөөнд харьцуулсан шинжилгээ хийсэн. Бүх их сургуулиуд эрхэм зорилгоо улс орныхоо нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар томъёолсон байна. Мөн алсын хараагаа “Судалгааны их сургууль болох”, “Азийн болон бүс нутгийн шилдэг сургууль” болох гэж тодорхойлсон байх бөгөөд алсын хараанд хүрэх урт хугацааны стратеги төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж иржээ. Хүснэгт 3-г их сургуулиудын алсын хараа, эрхэм зорилгыг нэгтгэн харуулав.

Хүснэгт 3. Алсын хараа, эрхэм зорилго, стратеги төлөвлөгөө

№		МУИС	ШУТИС	ХААИС	АШУҮИС
1	Алсын хараа	<u>Судалгааны их сургууль</u> болж Азийн шилдэг 100 сургуулийн эгнээнд багтаж орно	Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн, МУ-ын шинжлэх ухаан, техноло-гийн хөгжлийн гол тулгуур, нээлттэй, судалгааны их сургууль болно	Бүс нутгийг манлайлах <u>судалгааны их сургууль</u> болно.	НДБЭБүсийн анагаах ухааны шилдэг 100 <u>судалгааны их сургуулийн</u> нэг болно.
2	Эрхэм зорилго	Нийгмийн хөгжлийн суурь асуудлаар сургалт судалгааны ажлыг тогтвортой эрхэлж эрдэм мэдлэгийг түгээх	Нэр хүндээ тогтвортой өсгөж, Азийн шилдэг их сургуулиудын нэг болох	Мэдлэг инновацид суурилсан судалгаа үйлдвэрлэлийг хөгжүүлэх	Олон улсын болон үндэсний эрэлт хэрэгцээнд нийцсэн эрдэм шинжилгээ боловсрол эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх
3	Стратеги төлөвлөгөө	МУИС-ийн 2016-2024 он хүртэлх хөгжлийн стратеги төлөвлөгөө	ШУТИС-ийн хөгжлийн стратегийн замын зураглал мастер төлөвлөгөө 2012-2021	ХААН - КАМПУС Үйл ажиллагааны стратеги 2011-2021	АШУҮИС-ийн хөгжлийн бодлого 2015-2024
		8 жилийн төлөвлөгөө	10 жилийн төлөвлөгөө	10 жилийн төлөвлөгөө	10 жилийн төлөвлөгөө

Цаашлаад их сургууль тус бүрийн стратеги төлөвлөгөөнд энтрепренершип түншлэл, инноваци хамтын ажиллагааны талаар хэрхэн тусгасаныг авч үзэхэд МУИС болон АШУҮИС-иуд хамтын ажиллагааны үр дүнд сургуулийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэн санхүүгийн чадавхиа дээшлүүлж сургуулиа хөгжүүлнэ, ШУТИС болон ХААИС нь дээрх зорилгоос гадна түншлэгч байгууллагынхаа эрэлтэнд нийцүүлэн хамтран ажиллах, тэдний ашиг орлогыг нэмэгдүүлэн өрсөлдөх чадварыг нь дээшлүүлэхэд хувь нэмэр оруулна гэсэн зорилгуудыг тус тус тодорхойлсон байна. Хамтын ажиллагааны төрлүүдийн хувьд хамтарсан төсөл, гэрээт ажил, захиалгат сургалт, судалгаа явуулах зэрэг нийтлэг чиглэлүүдийг тусгасан байх бөгөөд ХААИС бусад сургуультай харьцуулахад харьцангуй олон чиглэлээр инноваци хамтын ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 4. Стратеги төлөвлөгөөнд *энтрепренершип, инноваци, хамтын ажиллагааны талаар тусгасан байдал*

МУИС	ШУТИС	ХААИС	АШУУИС
1. Стратеги			
Төр, олон нийт, хувийн хэвшил, аж үйлдвэр бизнесийн байгууллага, их сургуулийн түншлэлийг хөгжүүлэх	Дотоод гадаадын бүх хэлбэрийн хуулийн этгээд байгууллага, хувь хүмүүстэй өргөн хүрээнд хамтран ажиллаж түншлэл хамтын ажиллагааны үр ашигтай хэлбэрүүдийг сонгон хэрэгжүүлэх	Аж ахуй нэгж байгууллага, үйлдвэрлэгч болон хувь хүмүүстэй хамтран ажиллах	Дотоод гадаад байгууллагуудтай хамтран ажиллах
2.Хамтын ажиллагааны зорилго			
Сургуулийн санхүүгийн эх үүсвэрийг бий болгох, орлогоо нэмэгдүүлэх	Хамтын ажиллагааны агуулгыг нийгмийн эрэлтэнд нийцүүлэн шинэчилж түншлэлийг хөгжүүлэх	Сургуулийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хөдөө аж ахуйн салбарын бүтээмж, үйлдвэр эрхлэгчдийн ашиг орлогыг нэмэгдүүлэх	Их сургуулийг хөгжүүлэхэд хувийн хэвшлийнхний оролцоог нэмэгдүүлэн эдийн засгийн таатай орчинг бүрдүүлэх

Судалгааны дараагийн алхам маань их сургуулиуд энтрепренер үйл ажиллагааг хөгжүүлэхэд нэн тэргүүнд шаардагдах технологи дамжуулалт, оюуны өмчийн зохицуулалт, энтрепренер санаачлагыг дэмжих орчин, нөхцлийг бүрдүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээнүүдийг авахад хэрхэн анхаарал хандуулж буйд шинжилгээ хийсэн. Ингэхдээ тодорхой чиглэлүүдээр хичнээн заалт байгааг тодруулж, заалт тус бүртэй нарийвлан танилцсан.

Хүснэгт 5. Хамтын ажиллагааг хэрэгжүүлэх орчин, нөхцлийг бүрдүүлэх төлөвлөгөөт үйл ажиллагаа

	Үйл ажиллагааны чиглэл	МУИС	ШУТИС	ХААИС	АШУУИС
1	Судалгааны нээлттэй төв, лаборатори, техник тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, ашиглалт	3 заалт	2 заалт	3 заалт	1 заалт
2	Судалгаа шинжилгээний үр дүнд оюуны өмчийн хамгаалалт хийх оюуны өмчийн бүтэц, зохицуулалт	1 заалт	1 заалт	1 заалт	-
3	Оюуны өмчийг аж үйлдвэрт нэвтрүүлэх болон аж үйлдвэр их сургуулийг холбож өгөх технологи дамжуулах төв, лицензийн бүтэц, зохицуулалт	1 заалт	1 заалт	4 заалт	1 заалт
4	Их сургуулийн технологи (судалгааны үр дүн, мэдлэг) -ийг зах зээлийн шаардлагад нийцэхүйц байдлаар хөгжүүлэх үүрэг бүхий технологийн инкубатор	-	2 заалт	1 заалт	2 заалт
5	Их сургуулиас гарсан технологи дээр тулгуурлан шинэ бизнес эхлэх гарааны компани (старт-ап, сфин-офф) байгуулахад шаардлагатай хөрөнгө оруулалт хийх санхүүгийн механизм	-	1 заалт	1 заалт	-
6	Шинэ бизнес старт-ап, болон спин-офф компани байгуулан авч явах чадвартай боловсон хүчин бэлтгэх энтрепренер боловсрол олгох тогтолцоо	2 заалт	1 Заалт	1 заалт	-
7	Судалгааны мэдээллийн сан өргөтгөл, ашиглалт	1 заалт	2 Заалт	4 Заалт	1 заалт
8	Багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, урамшуулалын системийн сайжруулалт	6 заалт	-	2 заалт	-

Хүснэгт 1-5 -д харуулсан судалгааны үр дүнд дүгнэлт хийхэд манай их сургуулиуд алсын хараа, эрхэм зорилгоо судалгааны их сургууль болно гэж томъёолсон байх бөгөөд стратегийн төлөвлөгөөндөө энтрепренершип, инновацийн орчныг хөгжүүлэх, таатай нөхцлийг бүрдүүлэхэд анхаарал хандуулж ажиллахаар төлөвлөсөн нь сайшаалтай. Энэ нь их сургуулиудын цаашдын үйл ажиллагаанд тусгалаа олж дэвшилтэт өөрчлөлтүүд гарах эхлэл болно

гэж найдаж байна. Үүн дээр их сургуулиуд өөрсдөө энтрепренер байх үзэл баримтлалыг хөгжүүлэх, бүтэц зохион байгуулалтаа энэ зорилго руу чиглүүлж өөрчлөлт хийх, ингэснээр энтрепренершипийн хөгжил хурдасч нийгэм, эдийн засгийн гүйцэтгэлд үзүүлэх нөлөөлөл нь төдий чинээ их болох юм.

Профессор, багш нарын ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хийсэн шинжилгээ

Олон улсын туршлагаас харахад энтрепренер чиг үүрэг бүхий их сургуулиуд профессор, багш, судлаачдаа энтрепренер байх, шинэ бизнесийн байгууллага (new venture) бий болгон хөгжүүлэх, аж үйлдвэрүүдтэй хамтран судалгаа хийх, патентын эрхээ өөрсдөө эзэмших, худалдаалах, рояалти хүртэх зэрэг эрх чөлөөг олгодог байна. Ингэснээр их сургуулийн сургалт, судалгааны ажлын чанар үр дүн дээшилж их сургуулийн нийгэмд үзүүлэх нөлөөлөл, нэр хүнд өсдөг учиртай. Бидний сонирхон судласан дараагийн зүйл манай улсын их сургуулиуд профессор, багш нарын бүтээлийг хэрхэн үнэлж урамшуулдаг, гүйцэтгэлийн үнэлгээ болон урамшуулалын систем нь хир үр дүнтэй байдаг болохыг тодруулахаар их сургуулиудын гүйцэтгэлийн үнэлгээ, урамшуулалын системд харьцуулсан шинжилгээ хийлээ. Хүснэгт 6-д их сургуулиудын гүйцэтгэлийн үнэлгээнд энтрепренершип, инновацийг хөгжүүлэхтэй холбоотой шалгуур үзүүлэлтүүдийг харуулав.

Хүснэгт 6. Профессор, багш ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, харьцуулсан шинжилгээ

Шалгуур үзүүлэлтүүд		МУИС	ШУТИС	ХААИС	АШУҮИС
Б цаг	Оюуны өмчийн бүтээл (Патент , ашигт загварын гэрчилгээ, стандарт, техникийн заавар, бүтээгдэхүүний загвар)	5 Заалт	6 заалт	4 заалт	1 заалт
	Эрдэм шинжилгээ судалгаа төсөл гэрээт ажил (ААНБ-ын захиалгат болон гэрээт судалгааны ажил, технологи дамжуулах инноваци нэвтрүүлэх ажил, байгуулсан лицензийн тоо)	2 Заалт	4 заалт	3 заалт	3 заалт
В цаг	Мэргэжлийн болон нийгмийн үйлчилгээ - Байгууллага аж ахуй нэгжийн захиалгаар бодлогын баримт бичиг, илтгэл, төсөл боловсруулах, - Аж ахуйн нэгж байгууллагын хүсэлтээр мэргэжил арга зүйн зөвөлгөө өгөх	2 заалт	-	-	-

Дээрх үзүүлэлтүүд болоод их сургуулийн багш нараас авсан судалгааны үр дүнгээс харахад хамтын ажиллагаа, түншлэлийг идэвхжүүлэх, дэмжихтэй холбоотой үнэлгээний үзүүлэлтүүд хязгаарлагдмал, үнэлгээний процедур

шаардлага хангадаггүй, урамшуулалын систем хангалттай бус гэсэн дүгнэлтэд хүрсэн бөгөөд их сургуулийн багш, судлаачид нь энэхүү гүйцэтгэлийн үнэлгээ, урамшуулалын системийг өөрчлөн шинэчлэх зайлшгүй шаардлагатай байгаа гэдэгтэй санал нэг байсан.

Дүгнэлт

1990 оноос их сургуулийн стратегийн зорилго нь уламжлалт сургалт, судалгааг сайжруулах гэдгээсээ эдийн засгийн өсөлт, хөгжилд хувь нэмэр оруулах гэсэн “third-mission” зорилго рүү чиглэсэн. Дээд боловсролын хөгжлийн явцад сургалтын их сургууль, судалгааны их сургууль, энтрепренер их сургууль гэсэн концепцууд гарч ирсэн байдаг. Их сургууль аж үйлдвэрийн хамтын ажиллагаа нь эдгээр гурван концепцийг нэгтгэх боломжийг олгодог. Сургалтын их сургууль сургалт дээр төвлөрдөг, судалгааны их сургууль судалгаа хөгжилд төвлөрдөг. Харин энтрепренер их сургууль нь технологийг арилжаалах, спин-офф, старт-аппуудыг төрүүлэн гаргахад төвлөрдөг. Олон улсын туршлагаас харахад их сургуулиуд улс орны энтрепренершип түншлэл, инновацийг хөгжүүлэхэд маш чухал үүрэгтэй оролцдог бөгөөд их сургууль-аж үйлдвэр-засгийн газар гэх гурвалсан холбоог хангахад санаачлагчтай оролцож тэргүүн эгнээнд явдаг. Манай улсын хувьд их сургуулиуд энтрепренершип хөгжлийн асуудалд хэрхэн хандаж, үйл ажиллагаагаа явуулж байгаад судалгаа хийснээр дараах дүгнэлтэд хүрсэн. Үүнд:

- Их сургуулиуд зөвхөн судалгааны их сургууль болно гэсэн зорилгоор хязгаарлагдахгүйгээр хэрэгжилтийн үеийн удирдлагыг сайжруулах
- Их сургуулийн алсын хараа, эрхэм зорилгын биелэлтэд профессор, багш, судлаачид, байгууллагын гишүүдийг оролцуулах, зөв удирдлагаар хангах
- Их сургууль дотроо энтрепренершип үйл ажиллагааг дэмжих бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх
- Их сургуулийн эрдэмтэд, багш нарыг оюуны бүтээл бий болгоход урамшуулах
- Гүйцэтгэлийн системийг энтрепренер үйл ажиллагаатай уялдуулах, сайжруулах
- Байгууллагын бүх түвшинд энтрепренер үйл ажиллагааг дэмжих, идэвхтэй байх нөхцлийг бүрдүүлэх
- Судалгааны үр дүнг урамшуулдаг, үйлдвэрлэлд нэвтрүүлдэг сайн туршлага, стратегийг хэрэгжүүлэх, энэ асуудлаар санаачлагатай

ажиллаж Засгийн газарт санал оруулах, тогтолцооны хувьд өөрчлөлт шинэчлэл хийхэд хувь нэмрээ оруулах

- Оюуны өмчийг эзэмших ашиглах эрхийг зөв удирдаж, түүнээс олох орлогыг нэмэгдүүлэх, өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг механизмд маш хурдацтай шилжих
- Их сургуулиуд энтрепренер байх үүргээ биелүүлж нийгэмд үлгэр дуурайлал болох
- Энтрепренершипийн хөгжлийн талаар нийгэмд таниулах, салбарын судлаачдыг дэмжих, салбарт хийгдэж буй судалгааны ажлыг олон нийтэд ил болгох

Бид энэ удаагийн судалгаагаар их сургуулиудын энтрепренершип үйл ажиллагааг хөгжүүлэхэд нөлөөлдөг хүчин зүйлсүүдийн нэг болох энтрепренершипт чиглэсэн алсын хараа, стратеги төлөвлөгөөнд баримт бичгийн шинжилгээ хийсэн төдийгүй эдгээр нь багшийн гүйцэтгэлийн үнэлгээтэй хэрхэн уялдаж байгааг тодруулж дүгнэлт өгөхийг зорьлоо. Бидний дараагийн судалгаа их сургуулийн энтрепренершип боловсролын хөтөлбөр рүү чиглэн үргэлжилэх болно.

Ашигласан материал

- [1] Andreas Rauch, Robert van Doorn, Willem Hulsink, 2014, “A Qualitative Approach to Evidence-Based Entrepreneurship: Theoretical Considerations and an Example Involving Business Clusters”
- [2] Annamaria Inzelt, 2004, The evaluation of university-industry-government relationships during transition, *Research Policy* 33, 975-995
- [3] Ben Spigel Richard Harrison, 2017, “Toward a process theory of entrepreneurial ecosystems”
- [4] David A. Kirby, 2006, Creating Entrepreneurial Universities in the UK: Applying Entrepreneurship Theory to Practice, *Journal of Technology Transfer*, 31, 599-603
- [5] D. Enkh-Otgon, N.Oyunjargal, D.Battsetseg “Analysis on factors that affect cooperation between universities and business organization”, *Management and Innovation Scientific Journal* 02(12), p146-151, special issue for the International Conference on Innovation and Entrepreneurship Development
- [6] Einer Rasmussen, Odd Jarl Borch, 2010, University capabilities in facilitating entrepreneurship: A longitudinal study of spin-off venture at

- mid-range universities, *Research Policy* 39, 602-612
- [7] Elias G, Carayannis, Evangelos Grigoroudis, 2017, The theory of ecosystem as helix: an exploiting theory-building study of regional co-operative entrepreneurial ecosystems as Quadruple Helix Innovation Model, *R&D management*
- [8] Henry Etzkowitz, 2003, Research groups as 'quasi-firms': the invention of the entrepreneurial university, *Research Policy* 32, 109-121
- [9] Henry Etzkowitz, 2013, Anatomy of the entrepreneurial university, *Social Science Information* 52(3) 486-511
- [10] Henry Etzkowitz, Andrew Webster et al, 2000, The future of the University and university of the future: evolution of ivory tower to entrepreneurial paradigm, *Research policy* 29, 313-330
- [11] Henry Etzkowitz, Loet Leydesdorff, 2000, The dynamics of innovation: from national system and "Mode 2" to a triple helix of university-industry-government relations
- [12] J.Selvan Katz, Ben R.Martin, 1997, What is research collaboration?, *Research Policy* 26, 1-18
- [13] Jochen Ropke, 1998, The Entrepreneurial university", Department of Economics, Philips-Universitat Marburg, Germany
- [14] Kaihua Guo, 2019, Thoughts on the development of Innovation and Entrepreneurship Education in Chinese Universities, 4th Annual International Conference on Education Science and Education Management
- [15] Maribel Guerrero, David Urbano, 2010, "The development of an entrepreneurial university", *Journal of Technology Transfer* 37, 43-74
- [16] Pamela Mueller, 2006, Exploring the knowledge filter: How entrepreneurship and university-industry relationships drive economic growth, *Research Policy* 35, 1499-1508
- [17] Zoltan J.Acs et.al., 2014, National Systems of Entrepreneurship: measurement issues and policy implications, *Research Policy* 43, 476-494